



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdtg@khentii.gov.mn

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Л.МЭНДБАЯР ТАНАА**

2022.04.06 № 7/740

танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн уялдаа холбоо хангалтгүй, дээд газраас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг тухайн үед нь гаргаж явуулдаг, бүртгэл байхгүй, хяналтад авдаггүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан заалт байхгүй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилтоо арга хэмжээ болгож задлаагүй, суурь түвшин, хүрэх түвшин бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй байгаа ба төлөвлөлтөө сайн хийх шаардлагатай гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.7-д заасны хяналтад авч, жагсаалт гарган агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний холбогдох зорилтуудыг хэлтэс болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон задлахдаа суурь түвшингээ тодорхойлж, зорилтод түвшинд хүрэхүйц байдлаар зөв төлөвлөх

3. Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь аймгийн Засаг даргын 2021 оны 105 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

231060130

2.

үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"-ын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах

4.Байгууллагын бүтэц, ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийн шинжилгээ хийж, ажил үүргийн хуваарилалт, ажлын хийдэл, давхардлыг арилгах

5.Харилцаа хандлага, хувцаслалт, ажлын байрыг зөвшөөрөлгүй орхих, ажлаас хоцрох, үүрэг даалгаврын биелэлт зэрэг хяналтын хуудасны зөрчлийн үзүүлэлт дээр хэлтсийн дарга нар хяналт тавьж хяналтын хуудасны хэрэгжилтийг хангаж ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 04 сарын 13-ны дотор ирүүлнэ үү..

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

